

ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/07/-НА-СТА-ТШЗ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА  
ДӨРВӨН ЗУУН АРВАН ТАВ ДУГААР НЭЭЛТТЭЙ, ХААЛТТАЙ ХОРИХ  
АНГИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: [khishigjargalts@audit.gov.mn](mailto:khishigjargalts@audit.gov.mn)

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: [amarjargalo@audit.gov.mn](mailto:amarjargalo@audit.gov.mn)

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: [khurelbaatar@audit.gov.mn](mailto:khurelbaatar@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: [www.audit.mn](http://www.audit.mn)

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	12
3. Аудитын тайлан .....	13
3.1 Ерөнхий зүйл .....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт .....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	14
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
4. Аудитын илрүүлэлт.....	18
4.3 Албан шаардлага.....	18

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг  
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.24 № 01/52  
танай -ны № -т

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ  
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА ДӨРВӨН  
ЗУУН АРВАН ТАВ ДУГААР НЭЭЛТТЭЙ,  
ХААЛТТАЙ ХОРИХ АНГИЙН ДАРГА,  
ХУРАНДАА П.УУГАНБАЯР ТАНАА**

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.ХИШИГЖАРГАЛ  
15009231

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>214,791,036.50</b>	<b>219,714,789.27</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	26,129,216.88	24,142,706.87
<b>312</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	26,129,216.88	24,142,706.87
<b>3121</b>	<b>Төгрөг</b>	26,129,216.88	24,142,706.87
31211	Төрийн сангийн харилцах	26,129,216.88	24,142,706.87
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	188,661,819.62	195,572,082.40
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	43,194,321.00	42,740,561.00
35110	Тусгай зориулалттай материал	42,270,841.00	42,206,627.00
35130	Эм боох материал	923,480.00	533,934.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	6,766,159.00	4,007,005.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	80,426,339.62	91,419,516.40
35420	Аж ахуйн материал	60,268,104.00	60,268,104.00
35440	Түлш, шатах тослох материал	360,750.00	1,863,700.00
35450	Барилгын засварын материал	7,076,500.00	6,746,500.00
35460	Хүнсний материал	11,792,680.00	21,464,240.00
35470	Бусад хангамжийн материал	928,305.62	1,076,972.40
35600	Мал амьтад	58,275,000.00	57,405,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>3,339,002,207.37</b>	<b>3,192,181,468.31</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,339,002,207.37	3,192,181,468.31
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,862,584,963.79	2,715,791,468.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,037,468,972.00	3,037,468,972.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(401,360,535.20)	(503,525,802.64)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	215,737,826.00	215,737,826.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(142,659,254.47)	(177,673,540.16)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	383,842,151.63	411,534,057.91
39206	Хуримтлагдсан элэгдэл	(261,714,339.70)	(297,943,838.73)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	21,939,179.00	21,939,179.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(16,326,379.47)	(17,402,729.07)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	25,657,344.00	25,657,344.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	476,417,243.58	476,390,000.00
39301	Програм хангамж	4,437,692.31	4,437,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,410,448.73)	(4,437,692.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	476,390,000.00	476,390,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>3,553,793,243.87</b>	<b>3,411,896,257.58</b>

<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>31,889,216.88</b>	<b>32,643,706.87</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	31,889,216.88	32,643,706.87
<b>413</b>	<b>Өглөг</b>	31,889,216.88	32,643,706.87
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	31,889,216.88	32,643,706.87
41361	Байгууллагад төлөх өглөг	5,760,000.00	15,725,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	26,129,216.88	16,918,706.87
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>3,521,904,026.99</b>	<b>3,379,252,550.71</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	3,521,904,026.99	3,379,252,550.71
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	761,871,668.74	761,871,668.74
51101	Өмч: - төрийн	761,871,668.74	761,871,668.74
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	496,143,031.70	353,491,555.42
51210	Өмнөх үеийн үр дүн	496,143,031.70	496,143,031.70
51220	Тайланг үеийн үр дүн	-	(142,651,476.28)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,263,889,326.55	2,263,889,326.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>3,553,793,243.87</b>	<b>3,411,896,257.58</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,156,183,759.00</b>	<b>2,004,673,462.50</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>368,844,659.00</b>	<b>168,309,842.50</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	368,844,659.00	168,309,842.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	368,844,659.00	155,121,842.50
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	112,960,848.00	54,699,220.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	255,883,811.00	100,422,622.50
120009	Бусад орлого	-	13,188,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,787,339,100.00</b>	<b>1,836,363,620.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,787,339,100.00	1,836,027,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,787,339,100.00	1,836,027,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	335,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	335,820.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,269,665,912.97</b>	<b>2,147,324,938.78</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,269,665,912.97</b>	<b>2,147,324,938.78</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	2,215,691,395.29	2,082,136,742.91
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,244,763,587.83	1,229,561,437.70
210101	Үндсэн цалин	828,444,000.00	733,035,334.00
210102	Нэмэгдэл	410,235,252.83	496,392,842.70
210104	Урамшуулал	6,084,335.00	133,261.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,812,256.70	25,429,332.15
210201	Тэтгэврийн даатгал	2,041,222.26	-
210205	Эрүүл мэндийн даатгал	24,771,034.44	25,429,332.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	203,152,639.00	210,088,465.50
210301	Гэрэл, цахилгаан	158,132,092.00	153,763,900.00
210302	Түлш, халаалт	32,855,647.00	45,477,745.50
210303	Цэвэр, бохир ус	12,164,900.00	10,846,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	120,750,550.79	39,861,674.00
210401	Бичиг хэрэг	2,334,900.00	2,643,800.00
210402	Тээвэр, шатахуун	25,843,960.00	21,026,890.00
210403	Шуудан, холбоо, интэрнэгийн төлбөр	2,264,399.79	2,607,184.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,549,400.00	1,651,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	79,332,891.00	5,697,100.00
210408	Бараа материал ақталсны зардал	9,425,000.00	6,235,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	416,085,875.80	379,748,877.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,732,660.00	13,202,446.00
210502	Хоол, хүнс	303,344,122.00	337,008,130.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	98,009,093.80	29,538,301.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	3,409,500.00	8,443,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	664,000.00	490,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	600,100.00	423,500.00
210604	Урсгал засвар	2,145,400.00	7,529,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	6,018,680.00	7,589,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,793,300.00	3,902,804.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	620,180.00	577,350.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	947,200.00	582,200.00
210807	Газрын төлбөр	474,000.00	1,387,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	194,698,305.17	181,414,302.56
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	14,485,148.38	6,056,457.22
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	975,500.00	845,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	179,237,656.79	174,512,645.34
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	53,974,517.68	65,188,195.87
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	27,577,200.00	35,750,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	27,577,200.00	35,750,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,740,000.00	9,324,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,740,000.00	9,324,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	131,427.68	105,535.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	131,427.68	105,535.87
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24,525,890.00	20,008,260.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,525,890.00	20,008,260.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(113,482,153.97)</b>	<b>(142,651,476.28)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(113,482,153.97)</b>	<b>(142,651,476.28)</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	761,871,668.74	2,264,055,557.95	609,738,954.27	3,635,666,180.96
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	166,231.40	166,231.40
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>761,871,668.74</b>	<b>2,264,055,557.95</b>	<b>609,905,185.67</b>	3,635,832,412.36
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	(166,231.40)	-	(166,231.40)
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайланг үеийн үр дүн			(113,762,153.97)	(113,762,153.97)
C08	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>761,871,668.74</b>	<b>2,263,889,326.55</b>	<b>496,143,031.70</b>	3,521,904,026.99
D01	<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>761,871,668.74</b>	<b>2,263,723,095.15</b>	<b>382,380,877.73</b>	
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>761,871,668.74</b>	<b>2,263,889,326.55</b>	<b>496,143,031.70</b>	3,521,904,026.99
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				-
D08	Тайланг үеийн үр дүн			(142,651,476.28)	(142,651,476.28)
D09	<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>761,871,668.74</b>	<b>2,263,889,326.55</b>	<b>353,491,555.42</b>	3,379,252,550.71

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>2,004,920,842.79</b>	<b>2,039,126,697.13</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>217,713,170.47</b>	<b>202,868,613.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	217,713,170.47	202,868,613.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	217,713,170.47	189,680,613.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	217,713,170.47	189,680,613.00
120009	Бусад орлого	-	13,188,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,787,207,672.32</b>	<b>1,836,258,084.13</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1,787,207,672.32	1,835,922,264.13
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,787,207,672.32	1,835,922,264.13
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	335,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	335,820.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,992,663,420.55</b>	<b>2,041,113,207.14</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,992,663,420.55</b>	<b>2,041,113,207.14</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,938,820,330.55</b>	<b>1,976,030,547.14</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,244,763,587.83	1,229,561,437.70
210101	Үндсэн цалин	828,444,000.00	733,035,334.00
210102	Нэмэгдэл	410,235,252.83	496,392,842.70
210104	Урамшуулал	6,084,335.00	133,261.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	26,812,256.70	25,429,332.15
210201	Тэтгэврийн даатгал	2,041,222.26	-
210205	Эрүүл мэндийн даатгал	24,771,034.44	25,429,332.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	206,389,995.00	205,178,500.00
210301	Гэрэл, цахилгаан	158,611,145.00	153,941,100.00
210302	Түлш, халаалт	35,613,950.00	40,390,580.00
210303	Цэвэр, бохир ус	12,164,900.00	10,846,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	34,504,939.79	30,400,854.00
210401	Бичиг хэрэг	2,334,900.00	2,643,800.00
210402	Тээвэр, шатахуун	28,236,240.00	23,498,170.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,264,399.79	2,607,184.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,549,400.00	1,651,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	250,845,053.00	301,131,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	14,854,805.00	12,812,900.00
210502	Хоол, хүнс	235,990,248.00	288,318,490.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	4,820,380.00	25,453,776.28
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,385,280.00	17,700,876.28
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	553,700.00	553,700.00
210604	Урсгал засвар	1,881,400.00	7,199,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	160,000.00	-
210702	Дотоод албан томилолт	160,000.00	-

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	167,693,618.23	152,937,557.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	164,468,238.23	149,250,907.01
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	620,180.00	577,350.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	176,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	947,200.00	582,200.00
210807	Газрын төлбөр	474,000.00	1,387,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	2,830,500.00	5,937,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,855,000.00	5,092,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	975,500.00	845,200.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>53,843,090.00</b>	<b>65,082,660.00</b>
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	27,577,200.00	35,750,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	27,577,200.00	35,750,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,740,000.00	9,324,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,740,000.00	9,324,000.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	24,525,890.00	20,008,260.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	24,525,890.00	20,008,260.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГА АНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>12,257,422.24</b>	<b>(1,986,510.01)</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	12,257,422.24	(1,986,510.01)
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	13,871,794.64	26,129,216.88
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	26,129,216.88	24,142,706.87

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангила	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,871,450,300.00	1,871,217,024.13
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,871,450,300.00	1,871,217,024.13
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,832,256,300.00	1,832,106,624.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,229,561,700.00	1,229,561,437.70
210101	Үндсэн цалин	794,865,600.00	733,035,334.00
210102	Нэмэгдэл	429,896,100.00	496,392,842.70
210104	Урамшуулал	4,800,000.00	133,261.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	25,429,900.00	25,429,332.15
210205	Эрүүл мэндийн даатгал	25,429,900.00	25,429,332.15
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	205,178,500.00	205,178,500.00
210301	Гэрэл, цахилгаан	153,941,100.00	153,941,100.00
210302	Түлш, халаалт	40,404,000.00	40,390,580.00
210303	Цэвэр, бохир ус	10,833,400.00	10,846,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	30,188,900.00	30,065,034.00
210401	Бичиг хэрэг	2,422,200.00	2,643,800.00
210402	Тээвэр, шатахуун	23,586,200.00	23,162,350.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,614,700.00	2,607,184.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	112,800.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,453,000.00	1,651,700.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	301,131,900.00	301,131,390.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	12,812,900.00	12,812,900.00
210502	Хоол, хүнс	288,319,000.00	288,318,490.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	25,474,600.00	25,453,776.28
210601	Багаж, техник, хэрэгсэл	17,720,900.00	17,700,876.28
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	553,700.00	553,700.00
210604	Урсгал засвар	7,200,000.00	7,199,200.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	9,352,900.00	9,349,454.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,666,200.00	5,662,804.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,008,000.00	1,008,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	577,400.00	577,350.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	132,000.00	132,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	582,200.00	582,200.00
210807	Газрын төлбөр	1,387,100.00	1,387,100.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,937,900.00	5,937,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,092,500.00	5,092,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	845,400.00	845,200.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	39,194,000.00	39,110,400.00
<b>2131</b>	<b>Засгийн газрын урсгал шилжүүлэг</b>	35,792,400.00	35,750,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	35,792,400.00	35,750,400.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	3,401,600.00	3,360,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,401,600.00	3,360,000.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		105,535.87
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	1,871,450,300.00	1,871,322,560.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	1,836,027,800.00	1,836,027,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,836,027,800.00	1,836,027,800.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	35,422,500.00	35,294,760.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	35,422,500.00	35,294,760.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1.00	1.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	100.00	92.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	98.00	90.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>100.00</b>	<b>92.00</b>
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	100.00	92.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>335,820.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>335,820.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	335,820.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	335,820.00
210402	Тээвэр, шатахуун	335,820.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	335,820.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	335,820.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	335,820.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	26,129,216.88
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	24,142,706.87

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/39 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх зорилго бүхий байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн даргын 2021 оны А/04 тоот тушаалаар 2021 оны дотоод хяналт шалгалтын төлөвлөгөө, хуваарийг баталсан байна.

Дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгасны дагуу ангийн санхүүгийн албанд хяналт шалгалтыг хийж 11 зөвлөмжийг өгсөн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 2,004,673.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 30,070.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 24,056.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлыг өөрчлөлгүй 24,056.0 мянган төгрөгөөр тогтоосон.

### **3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Энэхүү Санхүүгийн тайлангаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын

Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккрузэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

**Орлого:**

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 1,836,027.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 54,699.2 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 100,422.6 мянган төгрөг, ахмадын сангийн орлого 13,188.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 335.8 мянган төгрөг, нийт 2,004,673.4 мянган төгрөг, өмнөх оноос 151,510.3 мянган төгрөгөөр буюу 7 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй орлоготой холбоотой байна.

**Зардал:**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 2,147,324.9 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 2,024,008.3 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,871,217.0 мянган төгрөг зарцуулсан байна.

**Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:**

Тус байгууллага төрийн сангийн 100140312062 тоот дансанд 2021 онд 1,871,322.5 мянган төгрөгийн орлого, 1,871,322.5 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн 100140312401 тоот дансанд 335.8 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна. Ахмадын сангийн 100140312503 тоот дансанд 13,188.0 мянган төгрөгийн орлого орж, 5,964.0 мянган төгрөгийн зарлага гарч, үлдэгдэл 7,224.0 мянган төгрөг байна. Ялтны нэрийн 100140312501 тоот дансны эхний үлдэгдэл 26,129.2 мянган төгрөг, орлого 133,027.6 мянган төгрөг, зарлага 142,238.1 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 16,918.7 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	26,129.2	24,142.7	-1,986.5
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	188,661.8	195,572.1	6,910.3
Үндсэн хөрөнгө	3,339,002.2	3,192,181.4	-146,820.8
Нийт хөрөнгө	3,553,793.2	3,411,896.2	-141,897
Өр төлбөр	31,889.2	32,643.7	754.5
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,521,904.0	3,379,252.5	-142,651.5
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,553,793.2	3,411,896.2	-141,897

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 24,142.7 мянган төгрөг болж буурсан нь ялтны нэрийн дансны үлдэгдэлтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 195,572.1 мянган төгрөг болж 6,910.3 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь бараа үнэ төлбөргүй ирсэн бараа материалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,192,181.4 мянган төгрөг болж 141,897 мянган төгрөгөөр буурсан нь элэгдлийн зардалтай холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 17,210.3 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 10,481.5 мянган төгрөг, нийт 27,691.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 3,379,252.5 мянган төгрөг болж 142,651.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,809,660.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,777,704.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 61,789.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвөөс 1,836,027.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 35,422.5 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь хангамж бараа материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг нэмэгдүүлж баталсантай холбоотой байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,871,450.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,836,027.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 35,422.5 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,836,027.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 35,294.7 мянган төгрөг нийт 1,871,217.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,871,217.0 мянган төгрөгийг зарцуулж, 105.5 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,871,217.0 мянган төгрөг буюу 99,9 хувьтай байгаа нь хангамжийн бараа материалын зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги тайлант онд ШШГЕГ-аас 335.8 мянган төгрөгийн орлого орж шатахуунд зарцуулсан байна.

Ахмадын санд 13,188.0 мянган төгрөгийн орлого орж, 5,964.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцсийн үлдэгдэл 7,224.0 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих ангийн ялтны нэрийн дансны үлдэгдэл 16,918.7 мянган төгрөг нь 223 ялтны нэрийн дансны үлдэгдэл бөгөөд эдгээр ялтнууд нь хувийн харилцах данс, банкны картгүй байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван тав дугаар нээлттэй, хаалттай хорих анги нь цалингийн сангаас 13,188.0 мянган төгрөгийг ахмадын санд шилжүүлж зарцуулсан нь зориулалт бус зардал бөгөөд санхүүгийн тайланд орлого болон цалингийн зардлыг бодитой бусаар нэмэгдүүлж байна.

Худалдан авалтуудыг Э-баримтаар бүрэн баримтжуулдаггүй, гэрээнд тусгадаггүй, хянаж ажилладаггүй байна.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 145 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээлэл байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 01/377 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогын бүртгэл, гэрээ, гэрээний хэрэгжилт, авлагын талаар дараагийн аудитаар анхаарах.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 84,859.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэнд 2 албан шаардлага бичив.

### 4.3 Албан шаардлага

Цалингийн сангаас 13,188.0 мянган төгрөгийг ахмадын санд шилжүүлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5."батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалт, "Үнэн зөв байдал" гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 71,671.3 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйл, 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Хорих 415	2	84,859.3					2	84,859.3		